



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 02 сарын 04 өдөр

Дугаар 20

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө данснаас хасч,  
залруулга хийх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 8.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Увс аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 886,712,400.00 (найман зуун наян зургаан сая долоон зуун арван хоёр мянга дөрвөн зуун) төгрөгийн балансын үнэ, 208,176,198.25 (хоёр зуун найман сая нэг зуун далан зургаан мянга нэг зуун ерэн найман төгрөг хорин таван мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий Цагдан хорих байр буюу Увс аймгийн Цагдаагийн газрын байрны баруун жигүүрийн хэсгийг данснаас хасч, залруулахыг зөвшөөрсүгэй.

2. Увс аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дарга Н.Мөнхжаргалд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгийн хедлэлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.2. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙНХЭЛТЕЙИН  
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙН  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Э.ЭРДЭНЭХИШИГ